

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

\_\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_\_\_\_

Улаанбаатар хот

Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн  
гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон  
харилцааг зохицуулах журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар  
зүйлийн 27.10 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг  
тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий  
газарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын  
үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж  
мөрдсүгэй.

Гарын үсэг

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн  
2023 оны ... дугаар сарын...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

**НЭРИЙН ДАНС НЭЭХ, БҮРТГЭХ, ХӨТЛӨХ, ДААТГУУЛАГЧИЙН  
ГАРААНЫ ҮЛДЭГДЛИЙГ ТООЦОХТОЙ ХОЛБОГДСОН  
ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилт нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлсөн даатгуулагчид тэтгэврийн даатгалын нэрийн данс (цаашид "нэрийн данс" гэх) нээх, уг дансны эхний үлдэгдэл тооцох, даатгуулагч болон ажил олгогчоос тэтгэврийн даатгалын нэрийн дансанд төлсөн шимтгэлийг бүртгэх, нэрийн дансны тухайн жилийн орлогод хүү тооцох, тэтгэврийн даатгалын нэрийн дансанд бүртгэсэн орлогын бодит мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хэсэг ("мөнгөжүүлсэн орлого")-ийг бүртгэх, нэрийн дансны бүртгэл тооцоо хөтлөх, нэрийн дансны цахим мэдээллийг ашиглах, даатгуулагчийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Нэрийн данс нээх**

2.1. Нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2-д заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагч бүрт тэтгэврийн даатгалын нэрийн данс нээнэ.

**Гурав. Нэрийн дансны гарааны үлдэгдэл тооцох**

3.1. Нэрийн дансны гарааны үлдэгдлийг 2000 оноос өмнө хөдөлмөр эрхэлж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид тооцох бөгөөд гарааны үлдэгдэл нь даатгуулагчийн нэрийн данс нээлгэсэн жилийн эхний үлдэгдэл байна.

3.2. Нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцоход дараах үзүүлэлтүүдийг харгалзана.Үүнд:

3.2.1. Даатгуулагчийн нэрийн данс нээлгэх хүртэл ажилласан хугацаа;

3.2.2. Нэрийн данс нээлгэх хүртэл ажилласан 10 жилийн доторх дараалсан аль илүү хөдөлмөрийн хөлс авч байсан 5 жилийн дундаж индексжүүлсэн хөдөлмөрийн хөлсний хэмжээ;

3.2.3. Сард төлбөл зохих шимтгэлийн хувь хэмжээ;

3.2.4. Сүүлийн 5 жилийн улсын дундаж хөдөлмөрийн хөлсний дундаж индекс.

3.3. Нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцоход энэ журмын 3.2-д заасан үзүүлэлтүүдийг харгалзан дараах томъёогоор бодно:

3.3.1. Нэрийн дансны гарааны үлдэгдэл:

$$A=(B \times B) * 96\%$$

A-нэрийн дансны эхний үлдэгдэл

B-сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээ

B-ажилласан нийт сар

96%-Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27.4-д заасны дагуу 4 хувийг хасаж тооцно.

3.3.2. Сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээ:

$$B=G \times D \times E$$

G-даатгуулагчийн сарын хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээ;

D-сүүлийн 5 жилийн улсын дундаж хөдөлмөрийн хөлсний дундаж индекс;

E-шимтгэлийн хувь.

3.4. Энэхүү журмын 3.2.1-т заасан ажилласан хугацааг нийгмийн даатгалын байгууллага дараах байдлаар тооцно. Үүнд:

3.4.1. Даатгуулагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө ажилласан хугацааг хөдөлмөрийн дэвтэр (тушаалын хуулбар, архивын лавлагаа, шүүхийн шийдвэр, цэргийн батлах зэрэг)-ийг үндэслэнэ.

3.4.2. Даатгуулагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс 1999 оны 12 дугаар сарын 31-нийг дуусталх шимтгэл төлсөн хугацааг нийгмийн даатгалын дэвтэр, мэдээллийн сан, шимтгэл төлөлтийн тооцооны хуудас зэргийг үндэслэн сараар тооцно.

3.5. Энэхүү журмын 3.2.2-т заасан дундаж индексжүүлсэн хөдөлмөрийн хөлсний хэмжээг нийгмийн даатгалын байгууллага дараах байдлаар тооцно. Үүнд:

3.5.1. Даатгуулагчийн 1995-1999 онд сар бүр шимтгэл төлж ажилласан 5 жилийн индексжүүлсэн (итгэлцүүрээр тооцсон) цалин хөлсний нийлбэрийг мөн хугацаанд шимтгэл төлсөн нийт сарын тоонд хуваана.

3.5.2. 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө ажиллаж байсан боловч 1995 оноос хойш нэрийн данс нээлгэх хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаагүй даатгуулагчийн сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг Засгийн газраас тогтоон тухайн үед мөрдүүлж буй цалин хөлсний доод хэмжээ (12 000 төгрөгөөр)-гээр тооцно.

3.5.3. Даатгуулагч нь нэрийн данс нээлгэх хүртэл хугацаанд сар бүр тасралтгүй шимтгэл төлж ажиллаагүй нөхцөлд түүний төлсөн нийт шимтгэлээс нь тооцож гаргасан цалин хөлсний нийлбэрийг шимтгэл төлсөн нийт сарын тоонд хуваана.

3.5.4. Даатгуулагчийн нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцох сарын цалин хөлсний дээд хэмжээ нь тухайн үед тогтоосон даатгуулагчийн шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

3.6. Энэ журмын 3.2.3, 3.2.4-д заасан хувь хэмжээ, хөдөлмөрийн хөлсний дундаж индексийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

### **Дөрөв. Нэрийн дансны эхний үлдэгдэл тооцох**

4.1. 2000 оноос өмнө хөдөлмөр эрхэлж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчдын нэрийн дансны эхний үлдэгдэл нь даатгуулагчийн нэрийн дансны гарааны үлдэгдэл байна.

4.2. Нэрийн дансны өмнөх оны эцсийн үлдэгдэл нь тухайн жилийн эхний үлдэгдэл байна.

### **Тав. Нэрийн дансны орлого, зарлага бүртгэх**

5.1. Нэрийн дансанд дараах орлогыг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд дараах байдлаар бүртгэнэ. Үүнд:

5.1.1. 2000 оноос өмнө хөдөлмөр эрхэлж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчдын нэрийн дансны гарааны үлдэгдлийг нэрийн дансны эхний үлдэгдлээр, 2000 оноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчдын эхний үлдэгдлийг тэгээр даатгуулагч тус бүр дээр нэрийн данс нээж нийгмийн даатгалын байгууллага бүртгэнэ.

5.1.2. Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийг нийгмийн даатгалын байгууллага холбогдох маягтын дагуу цахимаар хүлээн авч баталгаажуулан нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

5.1.3. Нийгмийн даатгалын сангаас төлөх шимтгэлийг холбогдох журмын дагуу баталгаажуулан даатгуулагч тус бүрээр бүртгэнэ.

5.1.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлөх шимтгэлийг холбогдох журмын дагуу баталгаажуулан даатгуулагч тус бүрээр бүртгэнэ.

5.1.5. Төрөөс төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлогыг холбогдох журмын дагуу баталгаажуулан даатгуулагч тус бүрээр бүртгэнэ.

5.1.6. Энэхүү журмын 5.1.2, 5.1.3, 5.1.4-д заасан шимтгэлийн орлогын 96 хувийг нэрийн дансанд, 4 хувийг хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зориулж тусад нь тусгай дансанд даатгуулагч тус бүрээр нийгмийн даатгалын байгууллага сар бүр бүртгэнэ.

5.1.7. Энэхүү журмын 6.1-д заасан хүүгийн орлогыг даатгуулагч тус бүрээр нэрийн дансанд нийгмийн даатгалын байгууллага жилд нэг удаа бүртгэнэ.

5.1.8. Нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогын хөрөнгө оруулалтын өгөөжийг даатгуулагч тус бүрээр нэрийн дансанд нийгмийн даатгалын байгууллага тухай бүрд нь бүртгэнэ.

5.2. Албан журмаар даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан, гурав хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг түүний сүүлийн 12 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас даатгуулагч, ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь бүртгэж, хүү тооцно.

5.2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн 1995 оноос өмнө цэргийн алба хаасан хугацаанд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр дараах орлогоос тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ.

5.2.2. цэргийн алба хаасан хугацаанд авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод энэ хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэсэн орлогоос;

5.2.3. холбогдох хууль тогтоомжийн дагуу цэргийн алба хаасан хугацааг өсгөн тооцох хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс;

5.2.4. Энэ хуулийн 23.1.4-т заасан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ.

5.2.5. Хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ.

5.3. Нэрийн дансны зарлагын бүртгэлийг дараах байдлаар бүртгэнэ.

5.3.1. Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн нэрийн данснаас сар бүр хасалт хийнэ.

5.3.2. Нэрийн дансны үлдэгдлээс мөнгөжүүлэн авсан зарлагыг нийгмийн даатгалын байгууллага хасаж бүртгэнэ.

### **Зургаа. Нэрийн дансны хүү тооцох**

6.1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ын 27 дугаар зүйлийн 27.6-д заасны дагуу мөнгөжүүлсэн орлогыг хассан нэрийн дансны эхний үлдэгдэл, бүртгэсэн шимтгэлийн орлогод жил бүр хүү тооцно.

6.2. Тухайн жилийн нэрийн дансны үдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн дараа оны нэгдүгээр улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

6.3. Нэрийн дансанд тооцох хүүгийн хэмжээг дараах томъёогоор гаргана.

$$X = (И, Д) \text{ (дундаж, багаар, ихээр) сонголт хийх}$$

И-өмнөх оны инфляцын түвшин;

Д-Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх жилийн дундаж хүүгийн хэмжээ.

### **Долоо. Нэрийн дансны эцсийн үлдэгдэл тооцох**

7.1. Даатгуулагчийн нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдлийг дараах томъёогоор бодно.

$$НД_{с2} = НД_{с1} - М + БШО + X_0$$

НД<sub>с2</sub>-нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл;

НД<sub>с1</sub>-нэрийн дансны тухайн жилийн эхний үлдэгдэл;

БШО-тухайн жилийн бүртгэсэн шимтгэлийн орлого;

X<sub>0</sub>-нэрийн дансны эхний үлдэгдлээс мөнгөжүүлсэн орлогыг хассан дүн, тухайн жилийн бүртгэсэн орлогод тооцсон хүүгийн орлого;

М-мөнгөжүүлсэн орлого.

7.2. Тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгийг дор дурдсан зориулалтаар зарцуулна.

7.2.1. хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэрт

7.2.2. тэжээгчээ алдсаны тэтгэвэрт

7.2.3. Бусад үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх

7.3. Давхар ажил эрхэлдэг даатгуулагчийн нэрийн дансанд бүртгэсэг тухайн жилийн шимтгэлийг тооцохдоо ажил олгогч тус бүрийн төлсөн шимтгэлийн нийлбэрээс 4 хувийг хасч тооцно.

7.4. Шилжилт хөдөлгөөн хийлгэсэн даатгуулагчийн нэрийн дансанд урьд нь нийгмийн даатгалын байгууллага бүрт бүртгэгдсэн шимтгэлийн нийлбэрээр түүний тухайн жилийн нийт шимтгэлийн орлого тооцогдоно.

### **Найм. Нэрийн дансны бүртгэл хөтлөх, тайлан мэдээ хүргүүлэх**

8.1. Нийгмийн даатгалын байгууллага нь нэрийн дансны анхан шатны дараах маягтуудыг хөтөлнө. Үүнд:

8.1.1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудас;

8.1.2. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны дэлгэрэнгүй бүртгэл;

8.1.3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны нэгдсэн тайлан;

8.1.4. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудсыг шалгуулах хүсэлт гаргах өргөдөл.

8.2. Нийгмийн даатгалын байгууллага нь нэрийн дансны дэлгэрэнгүй бүртгэлийг даатгуулагчийн шимтгэлийн тооцооны хуудсыг үндэслэн сар бүр бүртгэж, жилийн эцэст даатгуулагчийн нэрийн дансны үлдэгдлийг тодорхойлох бөгөөд уг бүртгэлийг холбогдох журмын дагуу архивт шилжүүлнэ.

8.3. Нийгмийн даатгалын байгууллага нь нэрийн дансны жилийн нэгдсэн тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан гаргана.

### **Ес. Нэрийн дансны үлдэгдлийг шалгах, даатгуулагчдад мэдээлэх**

9.1. Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэж тооцоо хийгдсэн даатгуулагчдын цалин хөлс, шимтгэл төлөлт, мөнгөжүүлсэн орлого, зарлагын жилийн эцсийн мэдээлэл, тайланг үндэслэн нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдлийг дараа оны 1 дүгээр улиралд багтаан шалгаж баталгаажуулна.

9.2. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчдын нэрийн дансны баталгаажуулсан дараах мэдээллийг дараа оны 2 дугаар улиралд багтаан цахим /албан ёсны цахим хуудас, аппликейшн/-д мэдээлэл байршуулна. Үүнд:

9.2.1. Тайлант хугацаанд шимтгэл төлсөн заавал даатгуулагчдын нэрийн дансны мэдээллийг холбогдох маягтын дагуу гаргана.

9.2.2. Тайлант хугацаанд сайн дураар даатгагчдын мэдээллийг маягтын дагуу гаргана.

9.3. Даатгуулагч нь цахимд байршуулсан нэрийн дансны мэдээлэл үнэн зөв, мөн эхэд хянаж, хэрэв мэдээлэл буруу байвал харьяа нийгмийн даатгалын байгууллагаар тухайн мэдээллийг залруулж авах эрхтэй.

### **Арав. Даатгуулагчийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийлвэрлэх**

10.1. Даатгуулагч нэрийн дансны мэдээллийн талаарх өргөдөл, гомдолоо харьяалах нийгмийн даатгалын байгууллагад бичгээр гаргана.

10.2. Нийгмийн даатгалын байгууллага нь хүлээж авсан даатгуулагчийн өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг холбогдох бусад нийгмийн даатгалын байгууллагаас авч, нэгтгэн түүний өргөдөл, гомдлыг барагдуулах үүрэгтэй.

10.3. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн гаргасан өргөдөл, гомдлыг нь “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай хууль”-д заасан хугацаанд шийдвэрлэнэ.

10.4. Нийгмийн даатгалын улсын байцаагч даатгуулагчийн нэрийн дансанд бүртгэгдсэн мэдээллийн үндэслэлийг ажил олгогчоос ирүүлсэн шимтгэл төлөлтийн тайлан, тооцооны хуудас, даатгалын гэрээнд тусгагдсан заалт, шимтгэд төлсөн орлогын баримт болон тэтгэврийн сангийн харилцах дансны гүйлгээ тулган шалгаж шийдвэрлэсний үндсэн дээр уг залруулсан зөв мэдээлэлд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулан нэрийн данс хариуцсан байцаагчид өгнө.

10.5. Нэрийн данс хариуцсан байцаагч нь залруулсан мэдээллийг тухайн халтсийн даргын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу шимтгэлийн байцаагчид өгч уг мэдээллийг засварлуулах бөгөөд тухайн ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцоог дахин нягталж, үлдэгдлийг баталгаажуулах замаар түүний нэрийн дансны мэдээллийг залруулна.

10.6. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн нэрийн дансны орлогын мэдээлэлтэй холбоотой зөрчлийг арилгаж, түүний өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар холбогдох тэмдэглэл хөтөлж, уг тэмдэглэлийг тухайн даатгуулагчийн гаргасан өргөдлийн хамт архивт хадгална.

**Арван нэг. Журмын хэрэгжилтэд тавих хяналт,  
хүлээх хариуцлага**

11.1. Энэ журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын холбогдох чиг үүрэг бүхий нэгж, нийгмийн даатгалын улсын байцаагч хяналт тавина.

11.2. Энэхүү журмыг зөрчигчдөд хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

- - - о О о - -